



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 19 өдөр

Дугаар 0/459

Ховд


Газар өмчлөх эрх шилжүүлэх тухай

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.3 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсгийг тус тус үндэслэн Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь

1. Аймгийн Засаг даргын 2005 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 144 дүгээр захирамжаар гэр бүлийн хамтын хэрэгцээнд дундаа хамтран газар өмчилсөн иргэдийн хэлцлийг харгалзан Жаргалант сумын Цамбагарав баг Их голын ард 700 м2 хэмжээтэй 1,750,000 төгрөгийн үнэ бүхий газрыг иргэн Дашхүүгийн Энхбаярт үнэ төлбөргүйгээр шилжүүлэн өмчлүүлсүгэй.

2. Иргэн Д.Энхбаярт шилжүүлсэн газарт хуулийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга (Э.Дөлбадрал), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Хоролсүрэн) нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2005 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн 144 дүгээр захирамжийн 99-101 дэх заалтад холбогдох хэсгийг хүчингүй болгосугай.



Б.ДҮГЭРЖАВ

8400 01 2313  
Zah A/459 tum



Аймгийн Засаг даргын 2022 оны 07  
дугаар сарын 19-ний өдрийн  
А/459 дүгээр захирамжийн хавсралт

**ГЭР БУЛИЙН ХЭРЭГЦЭЭНИЙ ГАЗАР ӨМЧЛӨХ ЭРХЭЭ НЭГ ГИШҮҮНДЭЭ  
ҮНЭ ТӨЛБӨРГҮЙГЭЭР ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭДИЙН ЖАГСААЛТ**

д/д	Овог нэр	Хаяг	Газрын хэмжээ /м2/	Газар өмчилж авсан захирамжийн огноо	Дугаар	Хавсралтанд орсон дугаар
1	Насаночир Ганчимэг	Цамбагарав баг 11-11 ТООТ	700	2005-06-10	144	99-101
2	Энхбаяр Одгэрэл					
3	Энхбаяр Одонтуяа					

-оОо-